



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2020 оны 6-р сарын 11-ээс  
6-р сарын 18-ны байдлаар



## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

*2020 оны 6-р сарын 11-ээс 6-р сарын 18-ны байдлаар*

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтвортжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 14 дэх дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

### 1

### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Их Британийн эдийн засаг 4-р сард түүхэн дээд түвшин болох 20 хувиар агшсаныг сарын үзүүлэлтүүд харуулж байна.** Цар тахлаас үүдэлтэй хөл хорионоос үүдэн эдийн засгийн гол салбаруудын үйл ажиллагаа хумигдav. Эдийн засгийн 80 гаруй хувийг бүрдүүлдэг үйлчилгээний салбар 4-р сард 19 хувиар агшжээ. Аж үйлдвэрлэлийн салбар 20.3 хувиар, тэр дундаа автомашины үйлдвэрлэл 28.3 хувиар буурсан нь 1968 оноос хойших хамгийн том уналт болов. Барилгын ажил зогссонтой холбоотойгоор барилгын салбар 40.1 хувиар буурсан байна. Их Британийн худалдаа аж үйлдвэрийн танхимиын эдийн засгийн тэргүүн Сурен Тиру хэлэхдээ эдийн засгийн ихэнх салбаруудад ажиллах хүч буурсан тул V-хэлбэрийн эдийн засгийн сэргэлтийн магадлал тун бага гэж мэдэгдлээ.
- **Английн төв банк 6-р сарын мөнгөний бодлогын хурлаар бодлогын хүрг 0.1 хувьд хэвээр үлдээсэн хэдий ч, актив хөрөнгө худалдан авах үйл ажиллагаагаа 100 тэрбум фунт стерлингээр нэмэгдүүлснээр нийт багцын хэмжээ 745 тэрбум фунт стерлинг болов.**

Гэхдээ мөнгөний бодлогын хурлын үеэр сөрөг хүүгийн талаар хэлэлцээгүй байна. Хэдийгээр 2-р улиралд эдийн засгийн уналт Инфляцын тайлангийн төсөөллөөс бага байхаар байгаа хэдий ч, эдийн засгийг дэмжих нэмэлт арга хэмжээ шаардлагатайг онцлов.

- **ОХУ-ын ажилгүйдлийн түвшин 5-р сард 6.1 хувьд хүрлээ.** Оросын үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн нэгдсэн холбооноос зохион байгуулдаг бага хурлын үеэр Хөдөлмөрийн сайд Антон Котяков хэлэхдээ “Дотоодын хөдөлмөрийн зах зээл КОВИД-19 цар тахлын оргил үеийг бусад орнуудаас харьцангуй хохирол багатай давсан” гэдгийг онцоллоо.
- **ОУВС-ийн Ерөнхий эдийн засагч Гита Гопинат энэ долоо хоногт нийтэлсэн блогтоо “**ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөхөөс бууруулах төлөвтэй байгаа бөгөөд дэлхийн эдийн засаг эргэн сэргэхэд эрсдэл, тодорхой бус байдал маш өндөр байгаа**”-г онцолжээ. Өмнөх хямралуудаас ялгаатай нь энэ удаагийн хямрал шокын хувьд том бөгөөд 1) аж үйлдвэрээс илүүтэй үйлчилгээний салбарт хүчтэй сөрөг нөлөөтэй, 2)**

инфляц, инфляцын хүлээлт харьцангуй бага, 3) бодит эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд эсрэг чиглэлд хөдөлж байгаа нь санхүүгийн зах зээлд тодорхой хугацааны дараа том савалгаа үүсгэж болзошгүйг мөн тэмдэглэв. ОУВС-ийн дэлхийн эдийн засгийн төлөв тайлан 6-р сарын 24-нд нийтлэгдэнэ.

- **Morgan Stanley хөрөнгө оруулалтын банк дэлхийн эдийн засгийн өсөлт огцом унаж, энэ оны 4-р улирлаас хурдтай сэргэх төсөөллийг 6-р сарын 15-нд гаргав.** Уг төсөөллөөр дэлхийн эдийн засгийн өсөлт 2-р улиралд 8.6 хувиар агшиж уналтын доод цэгтээ хүрэх бөгөөд түүнээс цааш сэргэж 2021 оны эхний улирал гэхэд 3 хувиар өсөхөөр байна. Энэ нь өмнөх төсөөллөөс 2 дахин хурц V хэлбэрийн өсөлт юм. Дэлхийн эдийн засаг хурдан сэргэхэд 3 гол хүчин зүйл нөлөөлнө гэж үзжээ. Үүнд: 1) КОВИД-19-ийн шок нь эндоген шок биш (дотоод тэнцвэр алдагдаагүй), 2) Санхүүгийн хөрвөх чадварыг эргэн сэргээхэд харьцангуй хялбар, 3) Бодлогын хариу үйлдлүүд шийдэмгий, том хэмжээтэй хэрэгжиж байна. Төсөөлөлд КОВИД-19-ийн хоёр дахь давалгаа намар гарч, үүнийг хэсэгчилсэн хөл хорио тогтоох замаар хязгаарлана, 2021 оны зунаас вакцин гарна гэж үзжээ. Мөн 2 дахь давалгаа гарсан хэдий ч, Азийн эдийн засгуудад эхнийх шигээ том сөрөг нөлөө үзүүлэхгүй, учир нь улс орнууд вирусийг хяналтад оруулах тал дээр энэ удаа илүү бэлтгэлтэй болсон гэв.

- **АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (ХНБ) бонд худалдан авалтаа өргөжүүлж, компаниудын бондыг худалдан авч эхлэхээ мэдэгдлээ.** Нөөцийн банк өмнө нь зөвхөн exchange-traded-funds (ETF)-ийг худалдаж авдаг байсан бол одоо анхдагч зах зээл дээр хувийн хэвшлийн бондын индексэд

бүртгэлтэй компаниудын үнэт цаас, бондыг худалдан авах юм. Ингэснээр компаниуд Засгийн газрын агентлагуудад нэмэлт хүсэлт гаргах шаардлагагүй, нээлттэй хэлбэрээр индекст бүртгүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан байхад л болох юм. Тус хөтөлбөрийн хүрээнд нийт 750 тэрбум ам.долларыг зарцуулахаар төлөвлөжээ.

- **Европын төв банкны Ерөнхийлөгч К.Лагард 6-р сарын 13-ны өдөр тавьсан илтгэлдээ Евро бүсийн эдийн засаг суурь төсөөллөөр 2020 онд 8.7% агших бол өөдрөг төсөөллөөр өсөлт - 5.9%, муу төсөөллөөр -12.6% байхыг онцлов.** Эдийн засаг хэрхэн сэргэх, вирусийн вакцин хэзээ бий болох нь тодорхой бус тул хөрөнгө оруулалт болон хэрэглээн дээр дарамт болж байна. Энэ үед өрхүүд 2008 оны хямралас ч илүү хуримтлуулж, хадгалах хандлагатай байгаа нь хэрэглээг хязгаарлаж, сэргэлтийг удаашруулах тул эдийн засгийг дэмжих шаардлагатайг хэлэв. Мөн вирусийн дараах эдийн засагт бүтцийн өөрчлөлт бий болж, үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн сүлжээний шат дамжлагууд хоорондоо “ойрхон зйтай” байх шилжилт хийгдэх бол үйлчилгээний секторт “зай барих” хандлага бий болно гэв. Е-коммерс, зайнаас ажиллах хандлага аль хэдийн бий болоод буйг онцлов. Төв банкууд богино хугацааны тогтвржуулах бодлого хэрэгжүүлж байгаа боловч, Засгийн газрууд эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, цахим болон ногоон шилжилт хийх, үйл ажиллагаа нь ихээхэн муудсан секторын ажиллах хүчнийг дахин сургаж бэлтгэх, өрсөлдөх чадвартай болгоход шийдвэрлэх үүрэгтэйг онцлов.
- **“Европын холбоо КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралд хамгийн ихээр өртөөд буй орнуудад туслах төсвийн багц арга хэмжээг**

яаралтай шийдэх ёстой” гэж Европын Төв банкны ТҮЗ-ийн гишүүн Фабио Панетта хэлэв. Тэрээр “төсвийн нэмэлт багц арга хэмжээг яаралтай, 2021 оны I улиралд багтаах, арга хэмжээ авахгүй удаах тусам эдийн засгийг дэмжих өртөг нэмэгдэнэ” гэдгийг анхаарууллаа. Өнгөрсөн сард Европын холбооноос 750 тэрбум еврогийн (500 тэрбумыг буцалтгүй тусlamж байдлаар олгох) багцыг санал болгосон хэдий ч, зарим санхүүгийн консерватив улс орнуудын эсэргүүцлээс болж уг хэлэлцээр хойшлогдоод байгаа бөгөөд 6-р сардаа тохиролцоонд хүрэх төлөвлүй байна.

- PwC компани 2020 оны 3-р сараас хойш КОВИД-19-ийн дэгдэлтийн талаарх дэлхийн томоохон компаниудын санхүү хариуцсан захирлуудын (CFO) бодол, тэргүүлэх чиглэлийг хянах судалгааг хийж байна. Нийт 23 орны 989 санхүү хариуцсан захирлууд дунд 6-р сарын 1-8-ны хооронд явуулсан санал асуулгын гол үр дүнгийн тоймоос харахад:

1. Санхүү хариуцсан захирлуудын хамгийн ихээр санаа зовниж байгаа 3 гол асуудал нь 1) дэлхийн эдийн засгийн уналт 60 хувь, 2) халдварын шинэ давалгаа гарах магадлал 58

хувь, 3) өөрсдийн компани, байгууллагад үзүүлэх санхүүгийн сөрөг нөлөө 47 хувь гэсэн байна.

2. “КОВИД-19 “танай компанийн орлого/ашигт ямар нөлөө үзүүлэх вэ?” гэсэн асуултад 53 хувь нь орлого/ашиг 25-аас дээш хувиар буурах хүлээлттэй байна гэж хариулав.
3. “Зайнаас ажиллахыг зогсоож, ажлын байрнаас ажиллаж эхлэхэд дараах зүйлсээс алийг нь хэрэгжүүлэх вэ?” гэсэн асуултад 52 хувь нь зайнаас ажиллах боломжийг сайжруулах, зайнаас ажиллах боломжтой хүмүүсийг байнгын зайнаас ажилладаг болгохоор төлөвлөж байгаа гэсэн байна.
4. Компанийн ашиг/орлогыг хурдацтай нэмэгдүүлэхэд хамгийн ихээр анхаарал хандуулах ёстой зүйлст: 1) бараа болон үйлчилгээний чанарыг сайжруулах (63%), 2) бараа, бүтээгдэхүүний үнийг шинэчлэх шаардлагатай (48%) гэж үзжээ.

## 2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Бээжин хотод 6-р сарын 11-16-ны өдрүүдэд КОВИД-19-ийн шинэ 139 тохиолдол бүртгэгдсэнээр эдийн засгийн ирээдүйн төлөв, сэргэлтийн талаарх тодорхой бус байдлыг нэмэгдүүлэв. Эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн хэвээр хэдий ч, дотоод эрэлт цар тахлын өмнөх түвшинд хүрэх хараахан болоогүй байгааг Блүүмбергийн эдийн засгийн шинжээчид онцолж байна.
- **Хятадын аж үйлдвэрлэл** 4-р сард 3.9 хувиар, 5-р сард 4.4 хувиар өсөв. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар буурсан бол сэргэлт үргэлжилсэнээр эхний 5 сард 6.3 хувиар агшжээ. Жижиглэн худалдааны салбар мөн 4-р сарын 7.5 хувийн буурсан бол 5-р сард 2.3 хувиар буурав. Ажилгүйдлийн түвшин өмнөх сард 6 хувь хүрсэн бол 5-р сард 5.9 хувь хүрч буурах төлөвтэй байна.
- **БНХАУ-ын аж үйлдвэрлэл сэргэж байна.** Аж үйлдвэрлэлийн 3 томоохон дэд бүлэг болох уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, дулаан, усны үйлдвэрлэлүүд 5-р сард өмнөх сараас өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа, боловсруулах үйлдвэрлэл 5-р сард өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар буюу хүлээлтээс өндөрөөр өсөв. Дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотой бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом өсч, хүнд механизм экскаваторын үйлдвэрлэл 5-р сард 62.1 хувиар нэмэгдэв.
- **Хятадын үйлчилгээний салбарын индекс** 5-р сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар нэмэгдэж, энэ онд ажиглагдсан анхны өсөлт болов. Үүнд мэдээлэл технологи, үл хөдлөх хөрөнгө болон санхүүгийн салбар харгалзан 12.9 хувь, 7.1 хувь, 5.2 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Цар тахлын нөлөөгөөр хамгийн ихээр буураад байсан зочид буудал, кеттерингийн үйлчилгээний салбар 4-р сард 33.7 хувиар буурсан бол 5-р сард 21.7 хувиар буурч агшилт нь багаслаа. Энэ нь эдийн засгийн идэвхжил алгуур сэргэж байгаа хэдий ч, хэвийн түвшинд хүрэх болоогүйг илтгэж байна.
- **Төсвийн хөрөнгө оруулалт** оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурсан бол оны эхний 5 сард 1.9 хувиар буурч, бууралт нь эрс багасав. Төсвийн хөрөнгө оруулалт 5-р сард 10 хувиар өсч 2019 оны 6.8 хувийн өсөлтөөс нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нь засгийн газрын багц арга хэмжээ эдийн засагт эерэгээр нөлөөлж байгааг илтгэж байна.
- **Жижиглэн худалдааны салбар** дахь худалдаа нэмэгдэж үүнээс хэрэглээний үндсэн бүтээгдэхүүнүүд (хүнс, ундаа, хувийн ариун цэврийн бүтээгдэхүүн гэх мэт), харилцаа холбооны тоног төхөөрөмж 5-р сард өмнөх оны мөн үеэс 10-аас илүү хувиар өсч, хүлээлтээс давав. Зайлшгүй бус бусад хэрэглээ ч мөн энэ сард өсөлттэй байв. Тухайлбал, автомашины борлуулалт Засгийн газраас авч хэрэгжүүлж буй дэмжлэгийн хүрээнд өмнөх оны 7-р сараас хойших хамгийн анхны жилийн өсөлт үзүүлсэн бол гоо сайхны бүтээгдэхүүний борлуулалт 5-р сард өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар нэмэгдээд байна.
- Шандонг мужийн далайн эргийн цахилгаан станцуудад газрын тос боловсруулах үйлдвэрүүдийн ашиглалтын түвшин 5-р сарын эцэст 75 орчим хувь хүрч нэмэгджээ. Энэ нь өмнөх жилийн ашиглалтын түвшнээс

өндөр харин 4-р сарын дүнгээс 65-70 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

- **Хятадын төсвийн бодлого:** Хятадын Ардын Их Хурлаар 2020 оны төсвийн алдагдлыг өсгөж, 3.6 хувьд хүргэхээр баталсан. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бондын арилжаа болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдээр нийт 2020 онд Хятадын Засгийн газар 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийх төлөвтэй байна. Цаашид зээлийн өсөлтөөр дамжуулж эдийн засгийг тэтгэх арга хэмжээнүүд үргэлжлэх хүлээлттэй байна. Юаниар шинээр олгосон зээлийн хэмжээ 4-р сард 1.7 их наяд юань байсан бол 5-р сард 1.48 их наяд юань хүрч хүлээлтээс багаар өсөв. Харин Засгийн газрын бонд олголтын квот 2019 онд 2.15 их наяд юань байсан бол 2020 онд 3.75 их наяд юань хүрч нэмэгдэхээр батлагдсан. Гэхдээ корпорэйт бонд өмнөх сарын түвшнээс мэдэгдэхүйц буураад байна.

**Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Их хурлаар эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан мөнгөний уян хатан бодлого баримтална гэдгийг мэдэгдсэн. Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд КОВИД-19-өөс үүдэн дотоод эдийн засагт ирэх дарамтыг саармагжуулахын тулд бодлогын хүүгээ 0.5-0.6 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна<sup>1</sup>. Түүнчлэн, ХАБ 6-р сарын 1-ний өдрийн мэдэгдэлдээ 400 тэрбум юанийн квоттой арилжааны банкуудын жижиг ААН-үүдэд олгосон зээлийг худалдаж авах зээлийн шинэ бодлогын хэрэгсэл хэрэглэхээр болсноо мэдэгдсэн. Энэхүү шинэ хэрэгслээр дамжуулж ХАБ арилжааны банкуудын олгосон зээлийн 40 хувийг авах боловч, зээлийн эрсдэлийг хүлээхгүй бөгөөд хүүгийн орлогыг авахгүй юм. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

<sup>1</sup> ХАБ өмнө нь бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байсан.

### 3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

#### USD, S&P:

- Ам.долларын DXY индекс сүүлийн 3 жилийн дээд түвшнээс 6.6%-иар буурч, тайлант хугацааны эцэст 97-д хаагдлаа. 6-р сарын эхний хагаст өдөр бүр дунджаар 0.7%-иар суларсаар байна.
- ХНБ-аас хүүг 2023 он хүртэл нэмэхгүй байх тухай мэдэгдэл болон төсвийн алдагдал ДНБ-ий 17.8%-тай тэнцэх тооцоотой байгаа зэрэг мэдээ гарсан нь ханшид дарамт үзүүлэв. Нөгөө талаас эрсдэл бага валют гэсэн утгаар эрэлт нэмэгдэж, ханш чангараах шалтгаан болж байна.
- Хувьцааны индексийн өсөлтийн дийлэнх хувийг технологийн салбарын компаниуд буюу коронавирусийн сөрөг нөлөөнд бага өртсөн ААН эзэлж байгаа нь бодит эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгийн захын хамаарал бага болсныг илтгэж байна.

#### GBP, FTSE:

- Тайлант хугацаанд фунт стерлинг ам.долларын эсрэг 0.1%-иар чангарт, 1.24 түвшинд хүрлээ. АНУ-ын дотоодын зөрчил тэмцлийн нөлөөгөөр ам.долларын ханш голлох валютуудын эсрэг суларч, фунт ам.доллартай харьцах ханшид эерэг нөлөө үзүүлэв.


#### CNY:

- Тайлант хугацааны турш юань ам.долларын эсрэг 0.9%-иар чангарт 7.07-д хүрлээ.
- Бээжин хотод коронавирусийн шинэ тохиолдол бүртгэгдсэн, Хонг Конгийн

тогтвортгүй байдал зэргээс үл хамааран хувьцааны индексүүд өссөөр байна.

- Төв банкнаас санхүүгийн захад хөрвөх чадварыг дэмжиж, санхүүжилтийн зардлыг бууруулах талаар авах арга хэмжээний тухай мэдэгдэл хөрөнгийн захын сэргэлтийг дэмжиж байна.

Зураг 1. Шанхай хувьцааны индекс



#### JPY, Nikkei:

- Иен ам.долларын эсрэг 109.7-д хүрч суларсан хэдий ч тайлант хугацааны эцэст 2.6%-иар чангарт 106.87-д хүрлээ.
- Nikkei индекс 3-р сарын алдагдлаа нөхөж, АНУ-ын ажилгүйдлийн түвшин сайжирсан мэдээгээр дээшилж 2-р сарын түвшинд эргэн очлоо.

#### EUR:

- Тайлант хугацаанд евро ам.долларын эсрэг 0.7%-иар чангарт, 1.12 түвшинд хүрэв.
- АНУ-д дэгдээд буй КОВИД-19 вирусийн тархалт буурахгүй байгаа, мөн цагдаагийн албан хаагчдын эсрэг цуглаан, үймээн самуун сүүлийн 1 сарын хугацаанд хүчээ авсан нь ам.долларын ханш голлох валютуудын эсрэг буурч, евро өсөлттэй байх нөхцөл болов.

Улсын онцгой комиссын ээлжит хуралдаан болж эх орондоо ирэх хүсэлтээ гаргасан иргэдийг долоодугаар сарын эхний хагаст татан авах тусгай үүргийн нислэгийн талаар хэлэлцэн шийдвэр гаргав. Энэ дагуу:

- 2020.07.02 Сөүл
- 2020.07.04 Токио
- 2020.07.07 Сөүл
- 2020.07.09 Истанбул /транзит/
- 2020.07.15 Сөүл /транзит/ чиглэлд тусгай үүргийн нислэг үйлдэхээр боллоо. Мөн БНХАУ-д байгаа 160 гаруй иргэнийг ойрын өдрүүдэд Замын-Үүд боомтоор татан авахаар шийдвэрлэлээ. БНХАУ-ын Бээжин хотын нэр бүхий хүнсний захуудад КОВИД-19 цар тахлын хоёр дахь давалгаа эхлээд байгаа учир 6 сарын 22-ноос 7 сарын 6-ны өдрийг хүртэл хугацаанд тус улсаас далайн гаралтай бүтээгдэхүүн импортоор оруулахыг түр хориглов. Мөн хурлаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тогтоосон зарим

хязгаарлалтыг сулруулах чиглэлээр санал боловсруулж танилцуулахыг холбогдох байгууллагуудын удирдлагад даалгалаа.

КОВИД-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан АНУ-д тусlamж үзүүлэх асуудлыг Монгол Улсын Засгийн газар хэлэлцэн шийдвэрлэсэн билээ. Энэ шийдвэрийн дагуу 2020 оны 6 дугаар сарын 21-ний өдөр АНУ-ын Засгийн газар, ард түмэнд хүргэх тусlamжийг хүргэхээр Монголын иргэний агаарын тээврийн МИАТ компанийн 7801 дугаартай шууд нислэг АНУ-ын Сиатль хотыг зорилоо. Уг нислэг нь Монгол Улсын АНУ-руу хийж буй анхны нислэг юм. Тус онгоц 6-р сарын 24-нд Монголд ирсэн юм. Зургаадугаар сард нийт есөн удаагийн нислэгээр 2,300 иргэнээ татан авах болсон.

**LIBOR:**

- Тайлант хугацаанд 1 сар хүртэлх хугацаатай LIBOR хүү өссөн бол бусад хугацааны хүү 0.1 хүртэл нэгж хувиар буурав. Улмаар өгөөжийн муруй нь шулуун болох шинж ажиглагдаж байна.

**АНУ-ЫН ЗГҮЦ:**

- АНУ-ын Ерөнхийлөгч Трамп дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор 1 их наяд ам.долларын төсөв батлуулах санал оруулсан нь ЗГҮЦ-ны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.
- Улмаар 10 жилийн хугацаатай үнэт цаас (ҮЦ)-ны өгөөж 0.69%, 2 жилийн хугацаатай ҮЦ-ны өгөөж 0.16% хүрч, 0.04 хүртэлх нэгж хувийн өсөлттэй байв. ХНБ-ны бодлогын хүү нам дор түвшинд тогтвортой байв.

Хүснэгт 1: Голлох хүүгийн өөрчлөлт

Индекс	Сүүлийн хаалт	14 хоног Δ	1 сар Δ	1 жил Δ	Оны эх Δ
Fed Overnight	0.08	▲ 0.03	▲ 0.03	▼ -2.28	▼ -1.47
Libor 1 week	0.11	▲ 0.02	▲ 0.02	▼ -2.24	▼ -1.48
Libor 1 month	0.19	▲ 0.02	▲ 0.02	▼ -2.19	▼ -1.54
Libor 3 month	0.31	▼ -0.04	▼ -0.07	▼ -2.08	▼ -1.59
Libor 6 month	0.42	▼ -0.09	▼ -0.17	▼ -1.88	▼ -1.48
Libor 12 month	0.58	▼ -0.10	▼ -0.14	▼ -1.72	▼ -1.42
Shibor O/N	2.13	▲ 0.03	▼ -0.37	▲ 0.68	▲ 0.69
Shibor 1 Week	2.15	▼ 0.00	▼ -0.46	▼ -0.24	▼ -0.29
Shibor 1 Month	2.05	▲ 0.62	▼ -0.76	▼ -0.84	▼ -0.85
Shibor 6 Month	2.13	▲ 0.58	▼ -0.77	▼ -0.84	▼ -0.89
Shibor 1 Year	2.30	▲ 0.53	▼ -0.68	▼ -0.92	▼ -0.79
US 2Y Treasury	0.19	▲ 0.03	▲ 0.02	▼ -1.55	▼ -1.38
US 10Y Treasury	0.69	▲ 0.04	▲ 0.03	▼ -1.33	▼ -1.18
Japan 2Y Treasury	-0.16	▲ 0.00	▲ 0.02	▲ 0.06	▼ -0.03
Japan 10Y Treasury	0.01	▲ 0.01	▲ 0.02	▲ 0.15	▲ 0.03
Bund 2Y Treasury	-0.68	▼ -0.01	▲ 0.01	▲ 0.06	▼ -0.07
Bund 10Y Treasury	-0.42	▲ 0.03	▲ 0.07	▼ -0.13	▼ -0.19
EONIA	-0.46	▼ 0.00	▼ 0.00	▼ -0.08	▼ -0.01

**SHIBOR:**

- SHIBOR 1-12 сарын хугацаатай хүү тайлант хугацаанд тус бүр 0.58-0.62 нэгж хувиар огцом өслөө. Богино хугацаат хүүний түвшин буурсан хэдий ч, долоо хоногийн хугацаат хүүний түвшин 6 сарын хүүгийн түвшнээс өндөр байна. Энэ нь юанийн өгөөжийн муруй урвуу хэлбэрт шилжиж буйг илтгэж байна.

**Бондын мэдээлэл:**

- Тайлант хугацаанд Монгол Улсын гадаад бондуудын үнэ 10.4% хүртэл өсч, улмаар өгөөж 4.5% хүртэл буурав.
- Ам.долларын өгөөж нам дор түвшинд тогтвортой байхад Монгол Улсын ам.долларын ҮЦ-ны өгөөж буурч буй нь хөрөнгө оруулалтын орчин сайжирч байгааг илтгэж байна.

Хүснэгт 2: Дотоодын үнэт цаасны өөрчлөлт

Үнэт цаас	Сүүлийн хаалт	Өөрчлөлт Δ			
		14 хоног	Сар	Жил	Оны эх
ЗГҮЦ 5 жил	\$113.3	▲ 9.1%	▲13.1%	▲ 1.8%	▼ -4.6%
ЗГҮЦ 10 жил	\$99.7	▲ 1.4%	▲9.9%	▼ -1%	▼ -3%
ЗГҮЦ 5 жил (2021)	\$104.3	▲ 0.5%	▲4.2%	▼ -6%	▼ -4.6%
ЗГҮЦ 7 жил	\$107.9	▲ 2.2%	▲11.9%	▼ -4.6%	▲ 2.2%
ЗГҮЦ (Гэрэгэ)	\$100.4	▲ 1.9%	▲11.5%	▼ -1.5%	▼ -3.0%
ХБ 5 жил (2023)	\$96.5	▲ 10.4%	▲10.0%		
Turquoise hills (CAD)	\$0.7	▼ -9.9%	▲16%	▼ -42%	▼ -6.7%
MMC (HKD)	\$0.4	▲ 12.5%	▼ -5%	▼ -65%	▼ -45.5%
Өгөөж					
ЗГҮЦ 10 жил (Чингис)	5.2	▼ -0.59	▼ -4.05	▲ 0.51	▲ 1.05
ЗГҮЦ 5 жил (Мазаалай)	4.5	▼ -0.89	▼ -5.34	▲ 0.40	▲ 1.51
ЗГҮЦ 7 жил (Хуралдай)	6.3	▼ -0.69	▼ -3.58	▲ 0.78	▲ 1.34
ЗГҮЦ 6 жил (Гэрэгэ)	5.5	▼ -0.73	▼ -4.10	▲ 0.40	▲ 1.01
ХБ 5 жил (2023)	7.6	▲ 0.00	▲ 0.00		